

Ерөнхийлөгч Дийр Ф.Угдорф

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх



Түүний зөөлөн мутраар хүрээлэгдсэн нь

Бусад хүмүүсийн адил би ихэвчлэн уран зураг, хөгжмийн гайхалтай бүтээлүүдээс сүнслэг нөлөөг мэддэг. Данийн зураач Франс Шварцийн зурсан *Цэцэрлэг дэх зовлон шаналал*¹ хэмээх гайхалтай бүтээлийн урд зогсож байсан үе маань тэдгээр тохиолдлын нэг нь билээ.

Энэхүү сэтгэл өвтгөм зураг нь Гетсеманийн цэцэрлэгт өвдөглөн залбирч буй Аврагчийг дүрсэлдэг. Түүнийг залбирч байхад тэнгэр элч дэргэд нь зогсоод тайтгарал, тэнгэрлэг тус дэм өгч, зөөлөн гараараа Түүнийг тэвэрдэг.

Уг зургийг харах тусам зүрх сэтгэл, оюун санаа минь үгээр илэрхийлшгүй хайр болон талархлын мэдрэмжээр бялхан дүүрдэг. Аврагч дэлхийн гэм нүглүүдийг Өөр дээрээ авснаар хүн төрөлхтний хамгийн агуу ажлыг хийж эхлэх тэр үед дэргэд нь байхад ямар байх байсныг би бага зэрэг ч гэсэн мэдэрч байна. Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдээ үзүүлдэг хязгааргүй хайр энэрлийг би бахдан гайхширдаг. Миний болон бүх хүн төрөлхтний төлөө нүгэлгүй Хүүгийн хийсэн зүйлийн төлөө би гүн талархлаар дүүрэн байна.

Бурханы Хүүгийн золиослол

Жил бүрийн энэ цаг мөчид бид Есүс Христийн бүх хүн төрөлхтний төлөө хийсэн золиослолыг дурсаж мөн тунгаан боддог.

Гетсеманиас Голгота хүртэл бидний төлөө Аврагчийн хийсэн зүйл нь миний оюун ухаанаас давсан ойлголт билээ. Тэрээр бидний нүглийн ачааг Өөр дээрээ авч, Адамын анхны зөрчил төдийгүй түүнээс хойш амьдарсан тэрбум, тэрбум бодгалийн нүгэл болон зөрчлийн мөнхийн төлөөсийг төлсөн юм. Энэхүү мөнхийн хийгээд ариун золиослол нь “Бүр бүхнээс хамгийн агуу Бурхан . . . өвдөхийн улмаас дагжин чичрэх, мөн сүв бүрээс цус шүүрэх, мөн бие хийгээд сүнс аль алиныг нь зовоход” (С ба Г 19:18) хүргэсэн юм.

Тэр миний төлөө зовсон.

Тэр та бүгдийн төлөө зовсон.

Энэ золиослолын нарийн утга учрыг тунгаах үед бодгаль минь талархлаар бялхдаг. Нүглийн толбо хэр хар эсвэл ачаа дарамт хэр даашгүй байгаагаас үл хамааран энэхүү бэлгийг хүлээн авч, Түүнд зүрх сэтгэлээрээ ойртох хэн ч байсан өршөөгдөж, нүглээсээ ангижирч чадна гэдгийг мэдэх нь намайг даруусгадаг билээ.

Бид дахин толбогүй, цэвэр ариун болгогдож чадна. Бид хайрт Аврагчийнхаа хийсэн мөнхийн золиослолоор дамжуулан гэтэлгэгдэж чадна.

Хэн биднийг тайтгаруулах вэ?

Бидний хэн нь ч Их Эзэний туулсан гүн зовлонг мэдрэхгүй ч бидний хүн нэг бүрд өөрийн гэсэн харанхуй болоод гашуун цаг мөчүүд болох уй гашуу, зовлон

шаналал маань тэсэхийн аргагүй мэт мөчүүд байх болно. Нүглийн дарамт болон уй гашуу маань биднийг өршөөлгүйгээр нухчин дарах цаг үе ирэх болно.

Хэдий тийм байсан ч гэсэн хэрэв бид зүрх сэтгэлээ Их Эзэнд хандуулах аваас Тэр биднийг лавтайяа мэдэж мөн ойлгох болно. Цэцэрлэгт болон загалмай дээр бидний төлөө амиа үл бодон зовсон Тэрбээр биднийг тайтгаруулалгүйгээр орхихгүй. Тэр биднийг хүчирхэгжүүлж, урамшуулан адислах болно. Тэрээр биднийг зөөлөн гартаа тэврэх болно.

Тэр бидэнд тэнгэр элчээс ч илүү Нэгэн байх болно.

Тэр бидэнд адислагдсан тайтгарал, эдгэрэл, найдвар болон өршөөлийг авчрах болно.

Учир нь Тэр бол бидний Гэтэлгэгч билээ.

Бидний Чөлөөлөгч.

Бидний нигүүлсэнгүй Аврагч, адислагдсан Бурхан.

ЭШЛЭЛ

1. Франс Шварцийн оршуулгаар нэгэн санваартан үг хэлэхдээ “түүний бүтээл нь тэнгэрлэгээр адислагдсан ба олон номлолоос ч илүү үнэ цэнэтэй санагдсан” (Эммили Буканан-Витлок, “History of Artists’ Lives Gives Greater Context for Exhibit,” *Deseret News*, 2013 оны 9-р сарын 29, deseretnews.com) гэжээ.

ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Хичээл заахаасаа өмнө заах хүмүүсийнхээ онцгой хэрэгцээг ойлгоход тань туслах Сүнсний удирдамжийг эрэлхийл. Та Ерөнхийлөгч Угдорфын захиасаас хуваалцахдаа Аврагч болон Түүний гэтэлгэх золиослолын талаар гэрчлэлээ хуваалцаарай. Та зааж байгаа хүмүүсээсээ Аврагчийн цагаатгал тэдний хувьд ямар утга учиртай болох мөн тэд өөрсдийн “харанхуй хийгээд гашуун мөчүүддээ” хэрхэн Их Эзэний тайтгарлыг мэдэрч байсан тухай асуухыг бодож үз.

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

Есүс Христээр ирэх ялалт

Нэрийг нууцлав

Би хэт их иддэг асуудалтай байсан юм. Миний шунахайран их идэх явдал намайг асар их гэм буруу,

бухимдал, гутралд тарчлааж байв. Асуудлаа даван туулахыг хичээх бүртээ би сул доройгоо мэдэрдэг байлаа.

Аврагчийн цагаатгал нь биднийг зөвхөн авраад зогсохгүй түүнчлэн биднийг гэтэлгэж мөн төгөлдөржүүлдэг ба энэ нь хэтрүүлэн идэх төгс бус зуршилд маань хүртэл хамааралтай гэдгийг би удаан хугацааны туршид үл тоосон.

Би өөрийгөө Аврагчид өгөхөөр шийдсэн юм. Тэгээд би залбирсан. Би ач ивээл хэрэгтэй байгаагаа мөн сул дорой байдлаа чин сэтгэлээсээ хүлээн зөвшөөрч, Тэнгэрлэг Эцэгээс бурханлаг тусламжаар намайг маргааш адислахыг гуйлаа. Би хайрт Эцэг маань хүүгээ адислах хэмжээлшгүй хүсэлтэй бөгөөд Өөрийн хүслийг биелүүлэх зүйрлэшгүй хүчтэй гэсэн нотолгоог тэр орой мэдэрсэн юм.

Түүнээс хойш би хоол руу өөрийн эрхгүй татагддаг байхаа больсон юм. Би Есүс Христ бол миний амжилтын шалтгаан гэдгийг мэднэ. Паулын хэлсний адил “Надад хүч өгөгч Түүгээр би бүгдийг хийж чадна” (Филиппой 4:13) гэдгийг би сурч байна. Бас би “Харин бидний Эзэн Есүс Христээр бидэнд ялалтыг өгдөг Бурханд талархал нь байх болтугай” (1 Коринт 15:57) гэсэн Паулын өөр нэг хичээлийг хэзээ ч мартажгүй байхыг хичээж байна.

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Аврагч таныг тайтгаруулна

Гэр бүлийн гишүүн эсвэл найзаасаа Аврагч түүнийг тайтгаруулж байсан үеийнх нь талаар асуу. Аврагч таныг тайтгаруулж байсан үеийг бодож үзээрэй. Та тэр тохиолдлоо зургаар илэрхийлж, орныхоо дэргэд өлгөвөл энэ нь танд Есүс Христ үргэлж таныг тайтгаруулахаар дэргэд чинь байх болно гэдгийг сануулж болох юм.



Есүс Христийн зан чанарууд: Удаан тэсвэрлэдэг мөн тэвчээртэй

Энэ материалыг залбирч судлан, хуваалцах зүйлээ мэдэхийг эрэлхийл. Аврагчийн амьдрал ба зорилгыг ойлгох нь Түүнд итгэх итгэлийг тань хэрхэн өсгөж, айлчлагч багшаар дамжуулан тань харж хандан, анхаарал тавьдаг хүмүүсийн амьдралыг хэрхэн адислах вэ? Нэмэлт мэдээллийг reliefsociety.lds.org-оос үзнэ үү.

Итгэл, Гэр бүл, Халамж

Энэ бол Аврагчийн зан чанаруудын онцлог талуудын тухай Айлчлагч багшийн захиасууд цувралын нэг хэсэг юм.

Тэвчээр нь ихэвчлэн чимээгүй, идэвхгүй зан төлөвийг бодогдуулагч Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф “Тэвчээртэй байх гэдэг нь идэвхгүй, хүлцэнгүй байна гэсэн үг биш, бас айдсаасаа болж юу ч хийхгүй байна гэсэн үг биш. Тэвчээр гэдэг нь тэвчин хүлээж байхдаа үргэлж юм хийж байхыг хэлдэг. Энэ нь . . . тэр зүйлээ орхилгүй . . . зүрх сэтгэлийн хүсэл минь биелэгдэх нь хойшилсон ч гэсэн бэрхшээлийг зоригтойгоор даван туулах явдал мөн. Тэвчээр гэдэг бол зүгээр нэг тэсвэрлэхийг биш; харин онцгой сайнаар тэсвэрлэхийг хэлдэг юм!” гэжээ.

Мөнх бус байдлын өмнөх амьдралд маань Тэнгэрлэг Эцэг Өөрийн сүнсэн хүүхдүүд бидэнд зориулж төлөвлөгөө бэлдсэн бөгөөд бид дэлхийд ирэх боломжиндоо баярлан уухайлсан (Иов 38:7-г үзнэ үү). Бид дэлхий дээрх амьдралдаа өөрсдийн хүслийг Түүнийхтэй нийцүүлбэл Тэрээр “олон бодгалийн авралын төлөө [биднийг] Өөрийн мутар дахь зэмсэг болгох болно” (Алма 17:11).

Ерөнхийлөгч Угдорф үргэлжлүүлэн, “Тэвчээртэй байх гэдэг нь өөрчилж болохгүй зүйлийг хүлээн зөвшөөрч, түүнийг зоригоор, нигүүлслээр, итгэлээр даван туулахыг хэлж байгаа юм. Энэ нь ‘бүр хүүхэд эцэгтээ захирагддаг шиг, Их Эзэний [бидэн дээр] ноогдуулах бүх зүйлийг хүлцэхэд бэлэн’ [Мозая 3:19] байна гэсэн үг. Эцэст нь, тэвчээртэй байх гэдэг нь өдөр бүр цаг тутамд, ингэх нь хэцүү байсан ч, ‘Их Эзэний зарлигуудыг дагахдаа . . . тууштай бас гуйвшгүй бас хөдөлшгүй’ [1 Нифай 2:10] байна гэсэн үг” гэжээ.¹

Нэмэлт судрууд

Дуулал 40:1; Галат 5:22–23;
2 Петр 1:6; Алма 17:11

Судруудаас

Дэлхий дэх амьдралдаа “зовлон зүдгүүрүүдэд тэвчээртэй байгтун, учир нь [чамд] эдгээр нь олон байх болно” гэж судрууд бидэнд хэлдэг. “Тэдгээрийг тэсвэрлэ, учир нь, харатгун, би чамтай, бүр чиний өдрүүдийн төгсгөл хүртэл хамт байх болно” (С ба Г 24:8) гэсэн тайтгаруулах амлалтыг Бурхан бидэнд өгдөг.

Библийн дараах түүх нь тэвчээр болон итгэлийн жишээ юм.

“Нэгэн эмэгтэй арван хоёр жилийн турш цус алддаг өвчтэй байсан бөгөөд . . . Есүсийн ард очиж, хувцасных нь хормойд гар хүртэл тэр даруй цус алдах нь зогсов.

Есүс - . . . Хэн нэг нь Надад хүрсэн. Учир нь Надаас хүч гарахыг Би мэдэрсэн гэжээ.

Өнөөх эмэгтэй анзаарагдахгүй өнгөрөөгүйгээ мэдээд, айн чичирсээр ирж Түүний өмнө унаж, ямар шалтгаанаар Түүнд хүрсэн хийгээд хэрхэн тэр даруй эдгэрснээ бүх хүмүүсийн өмнө ярилаа.

Есүс түүнд -Охин минь, итгэл чинь чамайг эрүүл болголоо. Амар тайван яв даа гэв” (Лук 8:43–48).

Тэр эмэгтэйн адил бид ч мөн Есүс Христийн цагаатгалаар эдгээгдэж чадах бөгөөд бид Түүнд хүрснээр тайтгарал, бүр эдгэргэлийн адислалыг олж чадна.

Эшлэл

1. Дийтр Ф.Угдорф “Тэвчээрээр үргэлжлүүл,” 2010 оны 4-р сарын ерөнхий чуулган, 68, 70.

Үүнийг эргэцүүлэн бод

Лук 8-р бүлэгт гарсанчлан уг эмэгтэйн олон жилийн тэвчээр болон Есүс Христэд итгэх итгэл нь хэрхэн шагнагдсан бэ?